

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр


№01

Засгийн газрын 8 дугаар байр
Олимпийн гудамж – 2
Сүхбаатар дүүрэг 14120
Монгол Улс
Утас: 264269

“Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн
сургалт эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.13, 25.14, “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 3.2.3.1, 3.2.5 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг Дорнод аймгийн аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 4 жилийн хугацаагаар олгосугай.
2. Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд “Ерөнхий мэргэшил судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох журмын дагуу баталгаажуулж олгох, сургалтын үйл ажиллагаанд явцын хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Я.АМАРЖАРГАЛ